

ХҮЙТЭН ДАЙНЫ ДАРААХ АНУ-ЫН МОНГОЛ СУДЛАЛЫН ЧИГЛЭЛҮҮД¹

Wei-chieh Tsai**

АНУ-ын монгол судлал гэж юу вэ?

Америкийн монгол судлаач хэмээх нэрийн дор янз бүрийн сургууль, боловсролтой хүмүүсийг ойлгох нь бий. Тэдний дунд монголыг судалдаггүй боловч, дам байдлаар монгол судлалтай холбогдсон судлаачдаас аваад монгол судлалыг сонирхогч өөр мэргэжлийн хүмүүс хүртэл багтдаг. Үнэндээ тэд өөрсдийгөө монгол судлаач гэж үздэггүй.

Америкт юуны өмнө Монголын эзэнт гүрний түүхийн судлаачийг ямагт монгол судлаач гэж үздэг. Тэдний судалгааны ажлын сэдэв нь гол төлөв Чингис хааны үеийн болон дараагийн дотоод азийн тал нутгийн эзэнт гүрний түүхийн тухай байдаг. Гэхдээ олонх судлаачид монгол хэл, бичиг мэддэггүй, гол төлөв Перс, Хятад хэл дээрх эх сурвалж ашигладаг.² Тэд нарын судалгаа нь Монгол эзэнт гүрний бүрэлдэхүүнд багтсан монгол бус хүмүүс, тухайлбал, Хятад, Араб эсвэл Персийн түүхийн судалгаа юм. Тиймээс эдгээр судлаачдыг монголын эзэнт гүрний үеийн Хятад эсвэл Персийн түүх судлаач гэж үзэх нь зүйтэй бөгөөд монгол судлаач гэж үзэх нь учир дутагдалтай.³

Удаах бүлгийн судлаачид орос, хятадын Монголчуудын түүх, соёлыг судалдаг. Жишээ нь William R. Jankowiak,⁴ Dee M. Williams⁵ ** АНУ-ын Индианагийн их сургуулийн Төв Еврази судлалын тэнхимийн докторант

1 Энэ өгүүллийн сэдвээр 2013 оны 11-р сарын 23-нд МУИС-ын ОУХС-ийн судалгааны семинарт уригдаж илтгэл тавьсан. МУИС-ийн багш П. Дэлгэржаргал, С. Энхцэцэг нар болон Д. Заяадэлгэр нарт өгүүлэлийн найруулгыг хянаж тусласанд гүн талархлаа илэрхийлье.

2 David Morgan Монгол эзэнт гүрний судлалд хамгийн чухал хоёр хэл бичиг нь Хятад ба Перс гэж боджээ. David Morgan, *The Mongols* (Second ed., Oxford: Blackwell, 2007), 2

3 Жишээ Thomas Allsen, Thomas Barfield, Hodong Kim, David Morgan, Donald Ostrowski, Peter Purdue, David M. Robinson, ба David Curtis Wright.

4 Jankowiak бол америкийн хүн судлаач. Тэрээр Өвөр Монголын Хөх хотод судалгаа хийжээ. Түүний судлалын сэдэв нь Хятад хотод секс, нас баралт ба нийгмийн давхаргын үелсэн байдал. William R. Jankowiak, *Sex, Death, and Hierarchy in a Chinese City: An Anthropological Account* (New York: Columbia University Press, 1992).

5 Williams бол америкийн хүн судлаач. Тэрээр Өвөр Монголын Улаанхад хотын Онниуд хошуугийн Ашхаан сумд судалгаа хийжээ. Түүний сэдэв нь өвст тал хашлага ба хүрээлэн буй орчны доройтол. Dee M. Williams, *Beyond Great Walls: Environment, Identity, and Development on the Chinese Grasslands of Inner Mongolia*

ба Michael Khodarkovsky⁶ нарыг нэрлэж болно. Эхний хоёр нь хятад тухай хүн судлаач, сүүлийнх нь оросын хил хязгаарын түүхчид юм.

Дараагийн бүлэг судлаачдад өнөөгийн Монгол улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн бодлого судлаач эрдэмтдийг оруулж болно. Тэд бас өөрсдийгөө мэргэжлийн монгол судлаач гэж үздэггүй бөгөөд ихэвчлэн эдийн засагч, улс төр, боловсрол судлаачид юм. Жишээ нь Iveta Silova, Gita Steiner-Khamsi,⁷ ба Keith Griffin⁸.

Дээрх гурван бүлэг судлаачдын судалгааны ололт амжилт монгол судлалд тустай боловч жинхэнэ монгол судлаачид биш юм. Christopher P. Atwood-ийн үзэж буйгаар АНУ-ын монгол судлаач гэж монгол хэл сурсан, монголоор уншдаг, АНУ-д монгол судлалаар судалгааны ажил хийдэг хүмүүсийг хэлж⁹ болно. Энэ утгаар нь авч үзвэл, америкийн монгол судлаачид цөөхөн боловч америкийн монгол судлалын байдлыг тодорхойлон ярих боломжтой юм. Жишээ нь Robert A. Rupen монгол хэл мэдэхгүй боловч Монгол улсын судлаачдын орос хэлээр бичсэн ном, өгүүлэл сайн ашигладаг учир түүнийг америкийн монголч гэж үзэж болно.

Дэлхийн II дайны өмнөх Америкийн монгол судлал

XX зууны эхнээс Америкийн зарим судлаач монгол хэл сурчээ. Жишээ нь Jeremiah Curtin. Curtin-гийн монголын тухай тэмдэглэл ба судалгааг түүнийг нас барсаны дараа түүний эхнэр найруулан хэвлүүлсэн. 1907 онд Berthold Laufer Чикаго хотын номын санд монгол гар бичмэл ба номыг эмхэлж өгчээ. 1920-иод онд Roy Char- (Stanford: Stanford University Press, 2002).

6 Khodarkovsky бол Америкийн Оросын хил хязгаарын түүхийн судлаач. Түүний судалгааны сэдэв нь Халимак Аюуш хан ба Хант Оросын Эзэнт Улсын харилцаа. Michael Khodarkovsky, *Where Two Worlds Met: The Russian State and the Kalmyk Nomads, 1600-1771* (Ithaca: Cornell University Press, 1992); *Russia's Steppe Frontier: The Making of a Colonial Empire, 1500-1800* (Bloomington: Indiana University Press, 2002).

7 Silova Steiner-Khamsi хоёрын шинжлгээний чиглэл нь төрийн бус байгууллага, даяарчлал ба Төв Азийн боловсролын шинэчлэлт. Iveta Silova and Gita Steiner-Khamsi, *How NGOs React: Globalization and Education Reform in the Caucasus, Central Asia, and Mongolia* (Bloomfield, CT: Kumarian Press, 2008).

8 Griffin бол Америкийн эдийн засагийн судлаач. Түүний судалгааны сэдэв нь Монголын зах зээлийн эдийн засаг ба ядуурал. Keith Griffin ed., *Poverty and the Transition to a Market Economy in Mongolia* (London & New York: St. Martin's Press, 1995); *Poverty Reduction in Mongolia* (Canberra: Asia Pacific Press, 2003).

9 Christopher P. Atwood, "The Academic Tradition of Mongolian Studies in the U.S.A.," Lecture given at Dankook University, Yongin, Gyeonggi Province, South Korea, October 29, 2008.

man Andrews Монгол ба Төв Азид хээрийн судалгааны ажил хийжээ.

1936 оноос Ferdinand D.Lessing Лос-Анжелес-ийн Калифорнийн их сургуульд монгол хэлний хичээл зааж байжээ. Гэхдээ энэ үед америкт монгол судлалын бие даасан төв байгуулагдаагүй байсан тул Орос, Герман, Франц, Япон зэрэг улсаас америкийн монгол судлал хоцорсон байв. Учир нь тэр үед монгол дахь АНУ-ын улс төрийн ашиг сонирхол бага байсантай холбоотой бололтой.

Дэлхийн II дайны дараах үеийн Америкийн монгол судлал

Дэлхийн II дайны дараа Зөвлөлт Орос, Хятадын монгол судлаачид коммунист дарангуйллаас зугтаж, АНУ-д олноор ирэх болжээ. Тухайлбал, Европоос Оросын Nicholas Porre, Унгарын Denis Sinor, Монгол улс болон Хятадаас Халхын Дилов хутагт, Чахар Г. Хангин, Дагуур У. Онон, Харчин Ж. Цэцэн, ба Хорчин Үнэнцэцэн (түүний хятад нэр Бао Гуо-и) нар АНУ-д иржээ. Дилов хутагтаас бусад монголчууд Дэмчигдонровын удирдсан Өвөр Монголын тусгаар тогтнолын төлөөх хөдөлгөөнд оролцож байсан байна.

Тэр үед Америкт Owen Lattimore, Francis Woodman Cleaves, ба Бельгийн Antoine Mostaert нарын монгол судлаачид байв. Тэд хамтран ажилласнаар Америкийн монгол судлалын төвүүдийг үндэслэн байгуулж, тэдгээрийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн ажээ.

Owen Lattimore бол америкийн монгол судлалыг үндэслэгч юм. Түүний «Хятад ба Дотоод Азийн хил хязгаар» ном нь одоо ч алдартай, сонгодог бүтээл хэвээрээ байна.¹⁰1939 онд тэрээр Хятадаас АНУ-д буцаж очоод Дилов хутагт, Г. Хангин, У. Ононтой хамтран дөрвүүлээ Жон Хопкинсийн их сургуулийн Пэйжийн нэрэмжит олон улс судлалын сургуульд Америкийн монгол судлалын анхны төвийг байгуулжээ. Гэхдээ 1950-иад онд америкт коммунизмын эсрэг үзэл давамгайлж, Lattimore-ийг коммунистуудын хамсаатан гэж буруутгах болсон тул тэрээр АНУ-аас гарч, Ангилд суурьшжээ. Иймээс Жон Хопкинсийн их сургуулийн монгол судлалын хөгжил түр зогссон байна.

Тухайн үед Lattimore-ийн байгуулсан монгол судлалын төвийн хөгжил түр зогссон боловч Америкийн бусад их сургуулиудад өөр монгол судлаачид байжээ. Жишээ нь Харвардийн их сургуулийн Алс дорнод судлалын тэнхимын профессор Francis W. Cleaves, Сиэтл хотод Вашингтонийн их сургуулийн Алс дорнод ба орос судлалын

10 Owen Lattimore, Inner Asian Frontiers of China (New York: American Geographical Society, 1951).

хүрээлэнгийн профессор Порре, Индианагийн их сургуулийн Урал ба Алтай судлалын тэнхимын профессор Sinor нар байв. Тэдний дотроос Порре-гийн нөлөө хамгийн их юм. Иймээс Порре-ийн талаар товч авч үзье.

Порре Америкт ирэхийн өмнө алдартай монголч эрдэмтэн болсон байв.¹¹ Тэрээр Оросын коммунист засгаас зугтан 1942 онд Германд ирж, 1949 онд АНУ-д шилжин суужээ. Вашингтоны их сургуулийн Алс дорнод ба Орос судлалын хүрээлэнд орж, Орос ба Германы Алтай судлалын уламжлалыг америкийн судлаачдад танилцуулжээ. Тэрээр Түвд судлалын эрдэмтэн Turrell Wylie, Хятад судлалын эрдэмтэн Herbert Franke, Lao Yan-shuan-тай хамт залуу монгол судлаачдын нэгэн үеийг бэлтгэжээ. Жишээ нь Robert A. Rupen,¹² John R. Krueger,¹³ James E. Bosson,¹⁴ Paul Buell¹⁵ нарын зэрэг алдартай монгол судлаачдыг нэрлэж болно.

Монгол судлаач Henry G. Schwarz¹⁶ 1963 оноос Висконсинийн их сургуульд улс төр судлалын докторын зэрэг хамгаалаад, Вашингтоны их сургуульд хичээл заах болсоноор Schwarz, Порре хоёр сайн найз болжээ. Түүнчлэх Үнэнцэцэн тус сургуульд «Монголын нууц товчоо»-

11 Порре-гийн гол бүтээл их олон байна. Жишээ нь Nicholas N. Poppe, *Grammar of Written Mongolian* (Wiesbaden: O. Harrassowitz, 1954); *Introduction to Mongolian Comparative Studies* (Helsinki, Suomalais-ugrilainen Seura, 1955); *The Mongolian Monuments in the Phagspa Script*, trans. and ed. John R. Krueger (Wiesbaden: O. Harrassowitz, 1957); *Buriat Grammar* (Bloomington, Indiana University, 1960); *Introduction to Altaic Linguistics* (Wiesbaden: O. Harrassowitz, 1965); and *The Twelve Deeds of the Buddha: a Mongolian Version of the Lalitavistara* (Seattle: University of Washington Press, 1967).

12 Robert A. Rupen, "Outer Mongolian Nationalism, 1900-1919" (PhD diss., University of Washington, 1954). Rupen дараах Хойд-Калолойнагийн их сургуулийн профессор болжээ. Гэхдээ түүний судалгааны чиглэл Монголын судлалаас коммунистын улсын судлалд өөрчилжээ. Хойд-Калолойнагийн их сургууль америкийн Монголын судлалын төв болсонгүй.

13 Krueger-гийн судалгааны чиглэл бол Баруун Монголчуудын түүх ба соёл. Жич тэрээр олон Европын Монголын судлалын уран бүтээл Ангил хэлээр орчуулжээ. Түүний докторын ажил: John R. Krueger, "Poetical Passages in the Erdeni-yin Tobci, a Mongolian Chronicle of the Year 1662 by Saγang Sečen" (PhD diss., University of Washington, 1960). Түүнийн бүр бүтээлийн ном зүй: William Rozycki, ed., John R. Krueger: *A Bibliography* (Bloomington: Eurolingua, 2001).

14 James E. Bosson, "A Treasury of Aphoristic Jewels: the Subhāsitaratnanidhi of Sa Skya Paṇḍita in Tibetan and Mongolian" (PhD diss., University of Washington, 1965).

15 Paul Buell, "Tribe, Qan and Ulus in Early Mongol China: Some Prolegomena to Yuan History" (PhD diss., University of Washington, 1977).

16 Henry G. Schwarz, *Leadership Patterns in China's Frontier Regions* (Washington, D.C.: Department of State, 1964).

ны 9-р бүлгийн тайлбараар магистрын зэрэг хамгаалжээ. Дараа нь Үнэнцэцэн Лос-Анжелес-ийн Калифорнийн их сургуульд монгол, хятад хэлний хичээл зааж, James Bosson-тай Хорчин хэл, соёлын тухай өгүүлүүд бичжээ.¹⁷

Роррег нас барсаны дараа Вашингтоны их сургууль монгол судлалыг үргэлжлүүлсэнгүй, Paul Buell эндэхийн Монгол судлалын хамгийн сүүлийн доктор нь болсон юм. Bosson Беркелигийн Калифорнийн их сургуульд, Krueger Индианагийн их сургуулийн профессороор ажиллах болсон. Schwarz, Buell хоёр Баруун Вашингтоны их сургуульд очиж ажиллажээ.

Sinor бол Индианагийн их сургуулийн монгол судлалыг үндэслэгч юм. 1939-өөс 1948 онд Францын хятад судлаач, нэрт эрдэмтэн Paul Pelliot-гаар монгол, турк хэл, түүх заалгажээ. 1948-1962 онд Английн Кембрижийн их сургуулийн дорно дахин судлалын коллежийн профессор байжээ. 1962 онд Америкийн Индианагийн их сургуульд ирээд Урал, Алтай судлалын тэнхим байгуулж, энэ нь 1993 онд Төв Еврази судлалын тэнхим гэж нэрлэгдэх болжээ. Түүнээс гадна 1967 онд Ази судлалын хүрээлэн байгуулж, тэр нь 1979 оноос Дотоод Азийн судлалын хүрээлэн гэж нэрлэгдэх болсон бөгөөд 2006 онд Sinor-ийн нэрэмжит болгосон байна. 1962 онд АНУ-ын засгийн газар Урал-Алтай хэл ба орон судлалын төвийг Колумбийн их сургуулиас Индианагийн их сургуульд шилжүүлж, 1981 онд улсын Дотоод Ази, Урал судлалын сурвалжийн төв гэж шинээр нэрлэжээ. Sinor нь Krueger, Хангины Гомбожав хоёрыг Индианагийн их сургуульд урьж ажиллуулсан байна. D. Sinor Индианагийн их сургуулийг америкийн Дотоод Ази, Монгол судлалын гол төв болоход голлох үүрэг гүйцэтгэсэн эрдэмтэн юм. Lattimore-ийг Англи явахад, Хангины Гомбожав Колумбийн их сургуульд орж магистрын зэрэг хамгаалаад, Инжинашийн «Хөх судар»-ын тайлбараар 1970 онд Индианагийн их сургуульд докторын зэрэг хамгаалжээ.¹⁸ Улмаар Индианагийн их сургуульд монгол судлалын профессор болжээ. Sinor, Krueger, Хангины Гомбожав зэрэг судлаачид Индианагийн их сургуульд хамтран ажилласанаар монгол болон дотоод Ази судлалаар

17 Kuo-yi Pao, "Marriage Customs of a Khorchin Village" Central Asiatic Journal, vol. 9 (1964): 29-59; "Family and Kinship Structure of the Khorchin Mongols" Central Asiatic Journal, vol. 9 (1964): 277-311; "Child Birth and Child Training in a Khorchin Mongol Village" Monumenta Serica, vol. 25 (1966): 406-439; and "The Lama Temple and Lamaism in Bayan Mang" Monumenta Serica, vol 29 (1970): 659-684.

18 John Gombojab Hangin, "The Literary Position of Injannasi's Kuke Sudur (The Blue Chronicle)" (PhD diss., Indiana University, 1970).

мэргэшсэн олон нэртэй Larry W. Moses,¹⁹ Stephen A. Halkovic, Jr.²⁰ зэрэг судлаачдыг бэлтгэн гаргажээ. Профессор Kueger-ийн халааг Унгарын нэрт монгол судлаач Gyurgy Kara залгамжлан авч ажиллаж байна.

Харвардын их сургуулийн монгол судлал америкийн эрдэм шинжилгээний нэгдэлийн гадна байжээ. Энэ нь дэлхийн II дайны өмнөөс эхлэжээ. Харвардын их сургуульд монгол судлалын судлаач Cleaves, Mostaert хоёр байжээ. *Cleaves* тэтгэлэг аваад Парист Pelliot-ийн шавь болсон ч, 1941 онд Франц-Германы дайн дэгдсэнээр Америкт буцан ирж, 1946 онд Харвардын их сургуулийн Алс дорнод судлалын тэнхимийн багш болжээ. Тус тэнхим 1972 онд Зүүн Азийн хэл ба иргэншлийн тэнхим гэж шинээр нэрлэгджээ. 1949 онд Mostaert АНУ-д нүүж ирсэн ч түүнд судалгааны ажил олдсонгүй. Cleaves, Mostaert хоёулаа олон монгол ном, судар бичиг ба хөшөөний чулуун дээрх бичээс хамтран тайлж уншин, хэвлүүлжээ. Cleaves «Монголын нууц товчоо»-ны англи хэлээр анхны бүрэн орчуулгыг гаргажээ. Гэхдээ Cleaves-гийн мэргэжил хэл бичгийн ухаан байсан түүнд Mostaert-ийн ордосын угсаатны зүйн бүтээлүүд болон орчин үеийн монголын түүх ба соёлын судалгаа сонирхолгүй байжээ.

Cleaves олон сайн судлаачдыг бэлтгэсний дотроос хамгийн авьяастай нь Joseph F. Fletcher, Jr. нар болно. Тэрээр 1984 онд нас баржээ. Харвардын их сургуулийн Зүүн ази судлалын дэг сургуулийн монгол судлалын онцлог нь судлаачид хятад, япон хэл сайтай байсанд оршино. Жишээ нь David M. Farquhar.²¹ Тэр Манжийн үеийн Монгол захиргааны систем тогтолцооны тухай докторын диссертация японы монголч Tayama Shigeru-ийн сургаалийг сайн ашиглажээ. Cleaves-г нас барсаны дараа түүний оюутан Elizabeth Endicott²² түүнийг залгамжилжээ. Нэг хэсэг Харвардад багшилж байсан Nicola Di Cosmo,²³ одоо Харвардад багшилж буй Mark C. Elliott²⁴ нарын хэн ч

19 Larry W. Moses, "Revolutionary Mongolia Chooses a Faith: Lamaism or Leninism" (PhD diss., Indiana University, 1972).

20 Stephen A. Halkovic, Jr., "Studies in Oirat Historiography: an Annotated Translation of Xalimaq хвдийн туужийг хурви бигсэн товчи оросибай" (PhD diss., Indiana University, 1977).

21 David M. Farquhar, "The Ch'ing Administration of Mongolia up to the Nineteenth Century" (PhD diss., Cambridge, Mass.: Harvard University, 1960).

22 Elizabeth Endicott, "Regional and Local Government in Yüan China" (PhD diss., Princeton University, 1982).

23 Nicola Di Cosmo, "Inner Asia in Chinese History: An Analysis of the Hsiung-nu in the Shih Chi" (PhD diss., Indiana University, 1991).

24 Mark C. Elliott, "Resident Aliens: The Manchu Experience in China, 1644-1760"

монгол судлалаар дагнан ажиллаагүй болно.

1972 онд Харвардын их сургууль Дотоод Ази ба Алтай судлалын хороо байгуулагджээ. Тус хороо бол Индианагийн их сургуулийн Төв Еврази судлалын тэнхимтэй адилхан олон чиглэлийн судалгаа явуулдаг төв юм. Гэхдээ тус хороо нь бие даасан зохион байгуулалтын нэгж биш, өөр тэнхимүүдээс багш нар ирж ажилладаг онцлогтой байжээ. Cleaves нас барсаны дараа өнөөг хүртэл тус хороонд монгол судлаач байхгүй байна.

Америкийн Монгол судлалын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн судлаач бол Жагчидын Цэцэн юм. Тэрээр 1949 онд Дундад иргэн улсын Гоминданий засгийн газартай Тайваньд нүүж ирээд, тэндээ улсын Чэнчи их сургуулийн Хил хязгаар судлалын хүрээлэнгийн захирал болжээ. Тиймээс Цэцэн багш Тайваны монгол судлалыг үндэслэн байгуулагч юм. 1972 онд Цэцэн Америкт шилжин ирж, Бригам Янг их сургуулийн профессор болжээ. Тэрээр Paul Hyer-тай хамтарч англи хэлээр зарим ном бичсэн. «Монголын соёл ба нийгэм»,²⁵ «Монголын нэгэн хутагтын намтар: Сүүлийн Ганжүрва Хутагт»,²⁶ «Цагаан хэрмийн дагуух энх тайван, дайн байлдаан ба худалдаа»,²⁷ «Сүүлийн монгол ноён: Дэмчигдонровын намтар ба түүний цаг үе (1902-1966)»,²⁸ ба «Монголын судлалын тухай уран бүтээлүүд»²⁹ зэрэг олон бүтээл туурвисан Цэцэн Америкт хамгийн алдартай монгол судлаачийн нэг болсон юм.

Дэлхийн II дайны дараа олон Халимаг дүрвэгч Оросоос АНУ-ын Нью-Жерси мужид суурьшжээ. Тэдгээр хүмүүсийн дундаас хамгийн нэртэй судлаач нь Араш Борманшинов юм. Түүний судалгааны гол бүтээл нь «Халимаг хэлний сурах бичиг» ба зарим халимагийн тухай өгүүллүүд болно.³⁰

(PhD diss., University of California at Berkeley, 1993).

25 Jagchid Sechin and Paul Hyer, *Mongolia's Culture and Society* (Boulder, Colo.: Westview Press, 1979).

26 Jagchid Sechin and Paul Hyer, *A Mongolian Living Buddha: Biography of the Kanjurwa Khutughtu* (Albany, N.Y.: State University of New York Press, 1983).

27 Jagchid Sechin and Van Jay Symons, *Peace, War, and Trade along the Great Wall: Nomadic-Chinese Interaction through Two Millennia* (Bloomington: Indiana University Press, 1989).

28 Jagchid Sechin, *The Last Mongol Prince: The Life and Times of Demchugdongrob, 1902-1966* (Bellingham, WA: Center for East Asian Studies, Western Washington University, 1999).

29 Jagchid Sechin, *Essays in Mongolian Studies* (Provo, Utah: David M. Kennedy Center for International Studies, Brigham Young University, 1988).

30 Arash Bormanshinov, *Kalmyk Manual* (New York: American Council of Learned So-

Колумбийн их сургууль дахь монгол судлалын бүтэлгүйтэл:

1950-аад оны эцэст АНУ-ын засгийн газар тус сургуульд Урал-Алтай судлалын судалгааны төсөл хэрэгжүүлжээ. Гэтэл санхүүжилтийн асуудлаас болж 1962 оноос зогсоож, Индианагийн их сургуульд шилжүүлжээ. Тус сургуульд байсан Монгол хэл шинжлэлч John C. Street³¹ Висконсины их сургуульд багшийн ажилд ороод тэндээ тэтгэвэрт гарталаа ажиллажээ. Колумбийн их сургуульд бие даасан монгол судлалын төв байсангүй. Тус сургуулийн монгол судлаач нь **Henry Serruys ба Morris Rossabi** хоёр юм. Henry Serruys, Mostaert хоёр адилхан Христосын шашны номлогчид байв. 1955 онд Serruys Колумбийн их сургуульд “Монгол ба Мин Хятад улсын харилцаа” сэдвээр докторын зэрэг хамгаалжээ.³² Хангины Гомбожав Индианагийн их сургуульд докторын сургалтанд орохын өмнө тус сургуульд магистрын зэрэг хамгаалжээ. Rossabi 1970 онд Колумбийн их сургуульд докторын зэрэг хамгаалаад,³³ Нью-Йорк хотын Куйнс коллежид ба Колумбийн их сургуульд профессор болжээ. Түүний судалгааны сэдэв нь Юан улсын түүх болон орчин үеийн Монголын түүх юм.³⁴ Тэрээр англиар Хубилай хааны намтрыг анх бичжээ.³⁵ Гэхдээ тэрээр Монгол хэлний эх сурвалж ашигладаггүй.

Товчоор хэлбэл, 1970-аас 1980-аад АНУ-ын монгол судлалын 5-н төв нь Вашингтоны их сургууль, Индианагийн их сургууль, Харвардын их сургууль, Баруун Вашингтоны их сургууль, Бригам Янг их сургууль

cities, 1961).

31 John C. Street, *The Language of the Secret History of the Mongols* (New Haven: American Oriental Society, 1957); “On the 14th Century Punctuation of Mongolian in the Yüan-chao pi-shih,” *Occasional Papers*, no. 12 (Bloomington: Mongolia Society, 1986).

32 Henry Serruys, “The Mongols in China during the Hung-wu Period, 1368-1398” (PhD diss., Columbia University, 1955).

33 Morris Rossabi, “Ming China’s Relations with Hami and Central Asia, 1404-1513: A Reexamination of Traditional Chinese Foreign Policy” (PhD diss., Columbia University, 1970).

34 Morris Rossabi ed., *China among Equals: The Middle Kingdom and Its Neighbors, 10th-14th Centuries* (Berkeley: University of California Press, 1983); Morris Rossabi, *China and Inner Asia: from 1368 to the Present Day* (New York: Pica Press, 1975); *Voyager from Xanadu: Rabban Sauma and the First Journey from China to the West* (New York and Tokyo: Kodansha America, 1992). Түүний хоёр хамгийн шинэ ном нь *The Mongols and Global History: A Norton Documents Reader* (New York and London: W. W. Norton & Company, 2011) ба *The Mongols: A Very Short Introduction* (Oxford and New York: Oxford University Press, 2012).

35 Morris Rossabi, *Khubilai Khan: His Life and Times* (Berkeley: University of California Press, 1988).

байв. АНУ-ын монгол судлал 1960-аас 1980-аад оны үед томоохон амжилтад хүрчээ. Учир нь АНУ-ын засгийн газар олон их сургуульд хөрөнгө оруулж, эрдэм шинжилгээний төвүүд байгуулж, гадаад улсаас монгол судлаачдыг америкийн их сургуулиудад ажиллуулж, тэрхүү бодлогын үр дүнд монгол судлал эрчимтэй хөгжжээ.

Хүйтэн дайны дараах үеийн АНУ-ын монгол судлал

Хүйтэн дайн төгсгөл болсноор дараа америкийн монгол судлал Монгол улс ба Өвөр монголын нээлтэй байгаа боломжийг ашиглахгүй харин ч энэ үеэс америкийн монгол судлалын хөгжил эсрэгээрээ суларсаар байна. Учир нь Poppe, Cleaves, Хангины Гомбожав зэрэг олон нэрт монголч эрдэмтэд нас баржээ. Индианагийн их сургуульд Монгол судлалын уламжлал байгаа боловч бусад их сургуулиудад Монгол судлал үргэлжилсэнгүй. Энэ үес Монгол судлал түүх, хүн судлал зэрэг өөр мэргэжлийн чиглэлтэй холбогджээ.³⁶

АНУ-д Монгол Улс буюу Өвөр монголоос ирсэн монголч судалгаа хийж байсан боловч тэдний дотор АНУ-д удаан суурьшсан хүн цөөхөн. Жишээ нь Нью-Йорк хотын их сургуулийн хүн судлаач У. Э. Була,³⁷ Макалестергийн коллежийн хүн судлаач Наранбилиг,³⁸ Массачусетсийн технологийн институтын хүн судлаач Б. Мандухай³⁹ ба Беркелийн Калифорнийн их сургуулын урлагийн түүх судлаач Ц. Уранчимэг (Орна)⁴⁰ зэрэг судлаачид байна. Гэвч Булаг, Наранбилиг нар Америкаас явсан төдийгүй америкийн Монгол судлалын уламжлалтай холбоогүй байна. Хааяа зарим Америкийн судлаачид

36 Жишээ нь Sherylyn Briller, “Whom Can I Count on Today? Contextualizing the Balance of Family and Government Old Age Support for Rural Pensioners in Mongolia” (PhD diss., Case Western Reserve University, 2000); Katherine Metzko, ‘It Didn’t Used to Be This Way’: Households, Resources, and Economic Transformation in Tunka Valley, Buriatia, Russian Federation” (PhD diss., Indiana University, 2003); Amy Moore, “Life Skills Education in Mongolia” (PhD diss., University of Wyoming, 2010).

37 Булаг одоо Камбрижийн их сургуулийн хүн судлалын тэнхимын уншигч (дэд профессор). Түүний судалгааны бүтээлүүд нь Uradyn E. Bulag, *Nationalism and Hybridity in Mongolia* (New York: Oxford University Press, 1998); *The Mongols at China’s Edge: History and the Politics of National Unity* (Lanham, Md.: Rowman & Littlefield Publishers, 2002); *Collaborative Nationalism: The Politics of Friendship on China’s Mongolian Frontier* (Lanham, Md.: Rowman & Littlefield Publishers, 2010).

38 Наранбилиг одоо БНХАУ-ын Шанхай хотын Фүдангийн их сургуулийн хүн судлалын профессор.

39 Manduhai Buyandelger, *Tragic Spirits: Shamanism, Memory, and Gender in Contemporary Mongolia* (Chicago and London: University of Chicago Press, 2013).

40 Uranchimeg Tsultem, “Ikh Khuree: A nomadic monastery and the later Buddhist art of Mongolia” (PhD diss., University of California Berkeley, 2009).

Монгол судлаачидтай хамтран судалгаа хийдэг.⁴¹

Америкийн Монгол судлалын өмнө тулгарч байгаа гол бэрхшээл бол өнөөг хүртэл Монгол судлал өргөн олонд танигдаагүй явдал юм. Хүйтэн дайны үеийн Америкийн шинжлэх ухааны хүрээнд Монгол судлал нь бие даасан сургалт, судалгааны төв болж чадаагүй байв. Жишээ нь дэлхийн II дайны дууссаны дараа байгуулсан эрдэм шинжлэгээний хүрээлэнгүүдэд Индианагийн их сургуулиас гадна бусад Монгол судлал нь Зүүн Азийн эсвэл Оросын бүс нутаг судлалын хүрээнд үйл ажиллагаа явуулж байжээ. Жишээ нь Харвардын их сургуулийн Алс дорнод судлалын тэнхим, Сиэтл хотод Вашингтонийн их сургуулийн Алс дорнод, Орос судлалын хүрээлэнд багтаж байв. Иймээс Монгол судлалын тусгай бие даасан институт байсангүй, Монгол судлаачидад Индианагийн их сургуулиас өөр газар ажлын байр байсангүй. Жишээ нь Индианагийн их сургууль төгссөн докторууд Thomas Ewing,⁴² Samuel M. Grupper,⁴³ William Rozycki,⁴⁴ Bruce Lippard,⁴⁵ ба Robert K. Doebler⁴⁶ нарт АНУ-ын их сургуульд ажил олдсонгүй. Одоо АНУ-ын Индианагийн их сургуульд ганц Монгол хэлний профессорын орон тоо байна. Тийм учраас өнөөгийн байдалд америкийн монгол судлал өөрийн орой зайг цэцэглүүлж, өргөжүүлэх хөгжүүлэх хэрэгтэй байна.

Өнөөг хүртэл АНУ-д Индианагийн их сургууль нь дэлхийн II дайны дараа үеэс Монгол судлалын уламжлал үйлчилсэн сургууль. Одоо тус сургуульд хуучин монгол бичиг, монгол хэлний хичээл заадаг. Тус сургуулийн слав, дорнод Европ, Төв Азийн хэлний зуны сургуульд анхан ба дунд түвшний монгол хэлний хичээл ордог. Sinor-ийн нэрэмжит Дотоод Азийн судлалын хүрээлэн ба Америкийн Урал

41 Жишээ нь Nicola Di Cosmo and Dalizhabu (Darijab) Bao, *Manchu-Mongol Relations on the Eve of the Qing Conquest: A Documentary History* (Leiden: Brill, 2003).

42 Thomas Ewing, "Chinese and Russian Policies in Outer Mongolia, 1911 to 1921" (PhD diss., Indiana University, 1977).

43 Samuel M. Grupper, "The Manchu Imperial Cult of the Early Ch'ing Dynasty: Texts and Studies of the Tantric Sanctuary of Mahakala at Mukden" (PhD diss., Indiana University, 1980).

44 William Rozycki одоо Японы Айзу их сургуулийн хэлний шинжилгээны төвд ажилтан. William Rozycki, "Mongol Elements in Manchu-Tungus" (PhD diss., Indiana University, 1983).

45 Bruce Lippard, "The Mongols and Byzantium, 1243-1341" (PhD diss., Indiana University, 1984).

46 Doebler одоо Ираны Курдистан их сургууль - Хевлер-д зааж байна. Robert K. Doebler, "Cities, Population Redistribution, and Urbanization in Mongolia: 1919-1990" (PhD diss., Indiana University, 1994).

ба Алтай хэл, орон зайн төв бас ажилладаг байна. Индианагийн их сургуульд 1961 оноос Хангины Гомбожавын байгуулсан “Монголын Нийгэмлэг” үйл ажиллагаа явуулдаг. Жил бүр зохион байгуулагддаг Төв Еврази судлалын бага хуралд монгол судлалаар илтгэл тавигддаг. Тус сургууль нь өнөөгийн АНУ-н монгол судлалын хамгийн том төв болж байна.

2002 онд Америкийн Монгол Судлалын Төв (АМСТ) байгуулагдсан нь чухал юм. Тус төв нь ашгийн бус, төрийн бус, эрдэм шинжилгээ, боловсролын байгууллага хэдий ч АНУ-ын засгийн газрын төсөв хүндрэлтэй байгаагаас дэмжлэг үзүүлэх боломжгүй байгаа нь Америкийн монгол судлалын хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Одоогоор Монгол улсын засгийн газар гадаад улсын Монголын судлалд туслахыг зорьж байгаа боловч одоохондоо тодорхой бодлого хэрэгжүүлэхгүй байна.

Өнөөгийн Америкийн монгол судлаач гол эрдэмтэдийн судалгаа:

Гыургу Кара: (монголчууд Хар Дорж гэдгээр сайн мэднэ) нь Унгарт төрсөн монголч эрдэмтэн бөгөөд 1961 онд Будапештийн их сургуулиас доткорын зэрэг хамгаалжээ. Түүний багш нь алдарт монголч Lajos (Louis) Ligeti ба түрэгч Gyula (Julius) Nymeth нар юм. Тэрээр 1964 оноос Будапештийн их сургуулын Дотоод Ази судлалын тэнхимын профессор болжээ. Дараа нь 1988 оноос Индианагийн их сургуулийн Төв Евроази судлалын тэнхимд монгол судлалын профессор болжээ. 2011 оны 7 сарын 11-нд 54 жилийн Алтай судлалын бага хуралд “наслалтын амжилт” шагнал авчээ.⁴⁷ Түүний судалгааны чиглэл нь Алтай хэл бичгийн ухаан. Түүний шинэхэн бичсэн ном нь «Унгар улсын шинжлэх ухааны академийн номын санд хадгалсан Монгол ба Манж хэлний гар бичиг ба модон сийлбэр»,⁴⁸ «Монгол нүүдэлчний бичиг: найман зуу гаруй монгол хэл бичгийн түүх»,⁴⁹ мөн «Соном Гарагийн Эрдэний Сангийн толь бичиг»⁵⁰ зэрэг

47 “Central Eurasian Studies Professor Kara Honored for Lifetime Achievements,” IU News Room, accessed July 31, 2011, <http://newsinfo.iu.edu/news/page/normal/19090.html?emailID=19090>.

48 Gyurgy Kara ed., *The Mongol and Manchu Manuscripts and Blockprints in the Library of the Hungarian Academy of Sciences* (Budapest: Akadémiai Kiadó, 2000).

49 Gyurgy Kara, *Books of the Mongolian Nomads: More than Eight Centuries of Writing Mongolian*, trans. by John R. Krueger (Revised and expanded version. Bloomington: Research Institute for Inner Asian Studies, Indiana University, 2005).

50 Gyurgy Kara, *Dictionary of Sonom Gara’s Erdeni-yin Sang: A Middle Mongol Version of the Tibetan Sa-skya Legs Bshad: Mongol-English-Tibetan*, assist. Marta Kiripol-

орно.

Alicia J. Campi: Смит Коллежид Алс дорнодын түүх сурч, 1969 онд сургуулиа төгсжээ. 1973 онд Харвардын их сургуулийн Дорнод ази ба Монгол судлалын магистр, 1987 онд Индианагийн их сургуульд Дотоод ази ба Алтай судлалын докторын зэрэг хамгаалжээ. Түүний багш Хангины Гомбожав, Larry W. Moses, Төвдын эрдэмтэн Thubten Jigme Norbu. Тэрээр одоогийн “Монгол Нийгэмлэг”-ийн захирал, АНУ-Монголын зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирлын албыг тус тус хашдаг. Түүний судалгааны чиглэл нь Монголын орчин үеийн түүх, олон улсын харилцаа. Тэрээр докторын диссертация Хаалган дахь Америкийн консулын архив ашиглаж “1915 - 1927 оны хооронд Америк-Монголын улс төрийн харилцаа”⁵¹ сэдвээр хамгаалсан. 2009 онд “XX зууны Америк-Монголын улс төрийн харилцаанд Хятад, Орос нөлөөлсөн нь”⁵² номоо хэвлүүлжээ.

Christopher P. Atwood: Харвардын их сургуульд Cleaves, Fletcher нараар хичээл заалгаж, тэдгээрийн шавь болж, 1986 онд сургуулиа төгсжээ. Дараа нь Guyu Kaга ба Larry W. Moses нарын шавь болж 1994 онд Индианагийн их сургуульд Төв Евро-Ази судлалын докторын зэрэг хамгаалжээ. Тэрээр одоо Индианагийн их сургуулийн Төв ЕвроАзи судлалын тэнхимийн дэд профессор. Түүний судалгааны гол чиглэл нь Өвөр Монголын орчин үеийн түүх ба Монголын эзэнт гүрний түүх. Тэрээр «Өвөр Монголын зогсонги үеийн (1911-1931) залуу монголчууд ба аюулаас хамгаалагч нар»⁵³ мөн «Монгол ба Монголын эзэнт гүрний нэвтэрхий толь бичиг»⁵⁴ номуудыг хэвлүүлсэн. Одоо «Богд Баатар биеэр дайласан тэмдэглэл»-ийн англи хэлний орчуулга, тайлбар дээр ажиллаж байна.

Robert W. Montgomery: 1994 онд Индианагийн их сургуульд Оросын түүхээр докторын зэрэг хамгаалжээ. Түүний дэд зэрэг нь Дорнод Ази ба Монгол судлал. Одоо тэрээр Балдвин-Валлас коллежийн Оросын түүхийн дэд профессор. Түүний судалгааны гол чиглэл нь Оросын Буриадуудыг захирсан бодлого. Докторын

sk6 (Leiden: Brill, 2009).

51 Alicia J. Campi, “The Political Relationship between the United States and Outer Mongolia 1915-1927: the Kalgan Consular Records” (PhD diss., Indiana University, 1987).

52 Alicia J. Campi, *The Impact of China and Russia on United States-Mongolian Political Relations in the Twentieth Century* (Lewiston, N.Y.: The Edwin Mellen Press, 2009).

53 Christopher P. Atwood, *Young Mongols and Vigilantes in Inner Mongolia's Interregnum Decades, 1911-1931*, 2 vols. (Leiden: Brill, 2002).

54 Christopher P. Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire* (New York: Facts On File, 2004).

диссертаци нь «Хаант Оросын сүүлийн үе ба Зөвлөлт засаглалын эхэн үеийн угаастан, соёлын бодлого: Буриадууд ба буриад хэл» 2005 онд хэвлэгджээ.⁵⁵

Johan Elverskog: 2000 онд Индианагийн их сургуульд Төв Евро-Ази судлалын докторын зэрэг хамгаалсан. Одоо Өмнө Методист их сургуульд Шашин судлалын тэнхимийн профессор болсон.⁵⁶ Түүнийн судалгааны чиглэл нь Манжийн үеийн монголын бурхны шашины түүх”, “бурхны шашин ба лалын шашины түүхийн харилцаа. Тэрээр «Уйгур бичгийн бурхны шашины судар»,⁵⁷ «Манай Их Чин гүрэн: Хятадын эзэнт улсын сүүлчийн үеийн монголчууд, бурхны шашин, улс орон»,⁵⁸ ба «Торгоны зам дахь бурхны шашин ба лалын шашин»⁵⁹ зэрэг ном хэвлүүлсэн. Мөн «Утай уул ба Чин улсын соёл»⁶⁰ ба «Өндөр Монголын буддын шашинтаны намтар»⁶¹ зэрэг номыг хянан тохиолдуулсан байна. «Сувд эрхи хэмээх бичиг: XIX зууны эхний Ордосын монголын түүх бичиг»⁶² ба «Эрдэнэ тунамал нэрт судар оршив: XVI зууны Алтан хан ба Монгол»⁶³ зэрэг эх сурвалжийг орчуулж, тайлбар хийсэн.

Peter K. Marsh: 2002 онд Индианагийн их сургуульд Төв ЕвроАзи судлалын докторын зэрэг хамгаалаад одоо Зүүн Бейгийн Калифорни мужийн их сургуульд хөгжим судлалын тэнхимын туслах профессор болж угсаатны хөгжим судлал ба хөгжмийн түүх заадаг. Түүний судалгааны чиглэл нь Монгол ардын болон поп хөгжим. Тэрээр докторын диссертация «Морин хуур ба Монголын уламжлалт сэргээн

55 Robert W. Montgomery, *Late Tsarist and Early Soviet Nationality and Cultural Policy: The Buryats and their Language* (Lewiston, N.Y.: Edwin Mellen Press, 2005).

56 Johan Elverskog, “A Critical Edition of the Tibetan Diamond Sutra with a Study of Buddhist Terminology in Four Mongolian Translations” (M.A. thesis, Indiana University, 1995); “Buddhism, History and Power: The Jewel Translucent Sutra and the Formation of Mongol Identity” (PhD diss., Indiana University, 2000).

57 Johan Elverskog, *Uyghur Buddhist Literature* (Turnhout: Brepols, 1997).

58 Johan Elverskog, *Our Great Qing: The Mongols, Buddhism, and the State in Late Imperial China* (Honolulu: University of Hawaii Press, 2006).

59 Johan Elverskog, *Buddhism and Islam on the Silk Road* (Philadelphia: University of Pennsylvania Press, 2010).

60 Gray Tuttle and Johan Elverskog, *Wutai Shan and Qing Culture*. *JIATS* 6 (Dec., 2011).

61 Johan Elverskog, ed., *Biographies of Eminent Mongol Buddhists* (Halle: International Institute for Tibetan and Buddhist Studies, 2008).

62 Johan Elverskog, *The Pearl Rosary: Mongol Historiography in Early Nineteenth Century Ordos* (Bloomington: Mongolia Society, 2007).

63 Johan Elverskog, *The Jewel Translucent Sūtra: Altan Khan and the Mongols in the Sixteenth Century* (Leiden & Boston: Brill, 2003).

төсөөлөл» сэдвээр бичиж 2009 онд хэвлүүлсэн.⁶⁴ Мөн Монголын хип-хоп хөгжим ба Монголын залуучуудын соёлын тухай өгүүлэл бичсэн.⁶⁵

Timothy May: 1996 онд Индианагийн их сургуульд Төв Еврази судлалын магистрын зэрэг,⁶⁶ 2004 онд Мадисоний Висконсиний их сургуульд түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан.⁶⁷ Одоо Хойд Жоржийн коллеж ба мужийн их сургуульд түүх, хүн судлал, философийн тэнхимийн эрхлэгч. Төв Еврази ба Ойрхи Дорнодын түүхийн профессор болсон. Судалгааны гол чиглэл нь Монголын эзэнт гүрний цэргийн түүх. Гол бүтээл нь «Монголын дайны урлаг»,⁶⁸ «Монголын соёл ба ёс заншил»,⁶⁹ «Дэлхийн түүхэн дэх Монгол эзэгнэл».⁷⁰ Одоо тэрээр «Монголын эзэнт гүрний нэвтэрхий толь бичиг» дээр ажиллаж байгаа ажээ.

Melissa Andrea Cakars: 2008 онд Индианагийн их сургуульд түүхийн ухааны докторын зэрэг хамгаалаад, одоо Филадельфи хотын Санкт-Иосифгийн их сургуульд түүхийн тэнхимийн туслах профессор болжээ.⁷¹ Түүний судалгааны чиглэл нь “Сибир дэх Зөвлөлтийн шинэчлэлийн үеийн Буриадууд”

Sarah Combellick-Bidney: 2009 онд Индианагийн их сургуульд улс төр судлалын докторын зэрэг хамгаалсан. Одоо Аугсбургийн коллежийн улс төрийн судлалын туслах профессор.⁷² Түүний судалгааны чиглэл нь даяаршлын үеийн Монгол улсын өрсөлдөх чадвар ба хөгжил.

Jonathan Schlesinger: 2012 онд Харвардын их сургуульд Түүх ба

64 Peter K. Marsh, *The Horse-head Fiddle and the Cosmopolitan Reimagination of Tradition in Mongolia* (New York: Routledge, 2009).

65 Peter K. Marsh, “Our Generation is Opening its Eyes: Hip-Hop and Youth Identity in Contemporary Mongolia,” *Central Asian Survey* 29, vol. 3 (Nov 2010): 345-358.

66 Timothy May, “Chormaqan Noyan: The First Mongol Military Governor in the Middle East” (M.A. thesis, Indiana University, 1996).

67 Timothy May, “The Mechanics of Conquest and Governance: The Rise and Expansion of the Mongol Empire, 1185-1265” (PhD diss., University of Wisconsin-Madison, 2004).

68 Timothy May, *The Mongol Art of War: Chinggis Khan and the Mongol Military System* (Yardley, Penn.: Westholme, 2007).

69 Timothy May, *Culture and Customs of Mongolia* (Westport, Conn.: Greenwood Press, 2009).

70 Timothy May, *The Mongol Conquests in World History* (London: Reaktion Books, 2011).

71 Melissa Andrea Cakars, “Being Buryat: Soviet Modernization in Siberia” (PhD diss., Indiana University, 2008).

72 Sarah Combellick-Bidney, “Contesting Development and Globalization in Mongolia” (PhD diss., Indiana University, 2009).

Дорнод Азийн хэлний докторын зэрэг хамгаалсан. Одоо Индианагийн их сургуулийн түүхийн тэнхимын туслах профессор.⁷³ Түүний судалгааны чиглэл нь Манжийн үеийн Монголын байгаль орчны түүх.

Benjamin Samuel Levey: 2014 Харвардын их сургуульд Түүх ба Дорнод Азийн хэл шинжлэлийн докторын зэрэг хамгаалсан. Өдгөө Дирборнийн Мичиганы их сургуулийн түүхийн тэнхимын туслах профессор.⁷⁴ Түүний судалгааны чиглэл нь Манжийн үеийн Зүүнгарын түүх юм.

Америкийн залуу монгол судлаачид, тэдний судалгаа:

Brian G. Baumann: 2005 онд Индианагийн их сургуулийн Төв Евразийн судлалын тэнхимд монгол судлалаар докторын зэрэг хамгаалжээ. Судалгааны чиглэл нь Монгол хэлний бурхны шашины судар дахь зурхай ба мэрэг төлөг.⁷⁵ Одоо тэрээр «Монголын нууц товчоо»-ны зурхай ба Италийн уран зохиолч А. Дантегийн «Дивин комеди» -д Монголын тухай мэдлэг сэдвээр судалгаа хийж байна.

Katherine Petrie: 2006 онд Индианагийн их сургуульд хүн судлалын докторын зэрэг хамгаалжээ. Судалгааны сэдэв нь өнөөгийн Монгол улсын наадмын ёслол ба Монгол нийгэм, улс төрийн өөрчлөлт.⁷⁶

Mikael Adrian Thompson: 2008 онд Индианагийн их сургуульд хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг хамгаалжээ. Судалгааны сэдэв нь Халх Монгол ярианы нууц -н гийгүүлэгч ба үйл үгийн хувиргалт.⁷⁷

Tristra Newyear Yeager: 2010 онд Индианагийн их сургуулийн Төв Еврази судлалын тэнхимд доктор зэрэг хамгаалжээ. Судалгааны сэдэв нь Халхын анхны жүжигч С. Буяннэмэхийн «Ойрх цагийн товч түүх буюу Сандо амбан» хэмээх жүжгийн англи хэлний орчуулга,⁷⁸

73 Jonathan Schlesinger, "The Qing Invention of Nature Environment and Identity in Northeast China and Mongolia, 1750-1850" (PhD diss., Harvard University, 2012).

74 Benjamin Samuel Levey, "Jungar Refugees and the Making of Empire on Qing China's Kazakh Frontier, 1759-1773" (PhD diss., Harvard University, 2014).

75 Brian G. Baumann, *Divine Knowledge: Buddhist Mathematics According to the Anonymous Manual of Mongolian Astrology and Divination* (Leiden and Boston: Brill, 2008).

76 Katherine Petrie, "Transformation and Persistence in the Performance of the Ikh Bayar Naadam Ceremony of Mongolia" (PhD diss., Indiana University, 2006).

77 Mikael Adrian Thompson, "A Study of the Analogical Extension of the Mongolian Hidden-n Declension in Colloquial Standard Khalkha" (PhD diss., Indiana University, 2008).

78 Tristra Newyear, "An Outline of Recent History: A Translation of the Mongolian Author Buyannemekh's First Play" (M.A. thesis, Indiana University, 2004).

мөн “Орчин үеийн Буриадын жүжиг”⁷⁹.

Andrew E. Shimunek: 2013 онд Индианагийн их сургуульд хэл шинжлэлийн ухаан ба Төв Евразийн судлалын докторын зэрэг хамгаалжээ. Түүний судалгааны чиглэл нь Хятад бичгийн бүтэц ба дунд үеийн Хятад хэлний авиа зүй, Сяньби-Монгол хэлний язгуурын онол.⁸⁰

Leland Liu Rogers: 2008 онд Индиана их сургуулийн Төв Еврази судлалын тэнхимд магистрын зэрэг хамгаалсан. Магистрын ажил нь «Чингис Ханы Алтан Төвч»-ийн орчуулга ба тайлбар, 2009 онд хэвлэгдсэн.⁸¹ Индианагийн их сургуулийн хүн судлал ба Төв Еврази судлалын тэнхимийн докторант. Түүний одоогийн сэдэв нь Монголчуудын генетикийн гарал үүслийн тухай юм.

Alice W. Seddon: 2009 онд Индианагийн их сургуульд Төв Еврази судлалын магистрын зэрэг хамгаалжээ. Түүний магистрын ажил XIX зууны сүүлийн үеийн Халх Засагт хан аймгийн туслах жанжин С.Лувсандондовийн уран бүтээлийн англи хэлний орчуулга, тайлбар.⁸²

Teresa Nichols: 2009 онд Питтсбургийн их сургуульд магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр одоо Индианагийн их сургуулийн хүн судлалын докторант. Түүний судалгааны чиглэл нь өнөөгийн Монгол улсын засгийн газар олон улсын төрийн бус байгууллагатай Монголын соёлын өвийн талаарх тохиролцооны тухай.

Wei-chieh Tsai: 2005 онд Тайваний Жен-жи их сургуульд угсаатны зүйн магистрын зэрэг хамгаалсан. Одоо Индианагийн их сургуулийн Төв Еврази судлалын докторант. Судалгааны чиглэл Манжийн үеийн Халх ба Өвөр Монголд нүүж ирсэн хятад иргэд хэрхэн монголжсон тухай юм.

79 Tristra Newyear Yeager, “The Drama of Enlightenment, the Discourse of Darkness: Buryat Grassroots Theater, 1908-1930” (PhD diss., Indiana University, 2010).

80 Andrew E. Shimunek, “Towards a Reconstruction of the Kitan Language, with Notes on Northern Late Middle Chinese Phonology” (M.A. thesis, Indiana University, 2007); “The Serbi-Mongolic Language Family: Old Chinese, Middle Chinese, Old Mandarin, and Old Tibetan Records on the Hsien-pei (Xianbei) Languages and Their Relationship to Mongolic, with Notes on Chinese and Old Tibetan Phonology” (PhD diss., Indiana University, 2013).

81 Leland Liu Rogers, *The Golden Summary of Činggis Qayan: Činggis Qayan-u Altan Tobči* (Wiesbaden: Harrassowitz Verlag, 2009). Түүний эх сурвалж нь Dorongγ-a, Činggis Qayan-u takil-un sudur orosibai. *Mongγol-qayučı teьken nom-un baylay-a. Hohhot: Цбцр Mongγol-un arad-un keblel-ьн qorigγ-a*, 1998.

82 Alice W. Seddon, “The Writings of General Lu: Religion and Rule in Khalkha Mongolia at the Turn of the 20th Century” (M.A. thesis, Indiana University, 2009).

Hosung Shim: Солонгосын Сөүлийн их сургуульд Hodong Kim-аас сураад одоо Индианагийн их сургуулийн Төв Еврази судлалын докторант. Түүний судалгааны чиглэл Монгол эзэнт гүрний замын систем ба Манжийн үеийн Зүүнгарын хаант улсын түүх.

Америк дахь Монгол судлаачид:

Л.Цэрэнчунт 1996 онд Хүмүүнлэгийн ухааны сургуульд магистр хамгаалжээ. Одоо Индианагийн их сургуулийн монгол хэлний багш. М.Саруул-Эрдэнэ МУБИС-ын хэл шинжлэлийн багш байж байгаад АНУ-ын Виржини мужийн Арлингтон хотод Монгол Соёлын Төв байгуулсан. Одоо тэрээр АНУ-ын Конгрессын ном санчаар ажиллаж байна.

Дүгнэлт

Америкийн монгол судлалын уламжлал дэлхийн II дайны дараах үеэс эхэлжээ. Зөвлөлт болон хятадын монгол судлаач эрдэмтэд коммунистуудын дарангуйллаас зугтаж АНУ-д олноор цагаачлах болсон нь монгол судлалыг АНУ-д хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Хүйтэн дайн дууссанаар Монгол улс, Хятадын Өвөр монгол харьцангуй нээлттэй болсон энэ боломжийг ашиглан америкийн монгол судлал хүчирхэгжээгүй, харин ч хүйтэн дайны үеийн эрчимтэй хөгжил нь удааширч байна. Америкийн монгол судлалын өмнө тулгараад байгаа гол бэрхшээл бол өнөөг хүртэл монгол судлал өргөнөөр танигдаагүй бөгөөд хүйтэн дайны үеийн америкийн шинжлэх ухаанд монгол судлал биеэ даасан сургалт, судалгааны зохих байр суурийг эзэлж чадаагүйтэй холбоотой. Монгол судлал Монголын эзэнт гүрний түүх ба Алтай судлалын хүрээнд явагдаж байсан бол одоо америкийн монгол судлал зургаан чиглэлийн судалгаатай хавсран хөгжиж байна. Үүнд:

1. Түвдийн бурхны шашины судалгааны хүрээнд Дотоод Азийн бурхны шашины соёлын судалгаа хамрагдаж байна.
2. Хятадын хил хязгаарын түүхийн хүрээнд Зүүн Азийн судлал багтаж байна.
3. Социализм судлалын хүрээнд Оросын Төв Азийн судлал орж байна.
4. Оросын түүхийн хүрээнд Орос дахь Монгол угсаатны түүх, тухайлбал, Буриад ба Халимаг судлал багтаж байна.
5. Торгоны зам судлалын хүрээнд Дотоод Азийн соёлын

солилцооны түүхийн судалгаа орж байна.

6. Өнөөгийн Монгол улсын талаарх судалгаа хүмүүнлэгийн ба нийгмийн шинжлэх ухааны салбарт явагдаж байна.